



ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улс 2001 онд анх Галт зэвсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдөж байна.

Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” хэсгийн 4.2.1.16-д “Иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх сургалт, авран хамгаалах зохион байгуулалтыг дэмжин ажиллах, орон нутгийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний тогтолцоог бий болгоно.” гэж; 4.4.3.3-т “Сөрөн тэсвэрлэх чадавх-Батлан хамгаалах тогтолцоо” зорилтын хүрээнд батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 4-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” гэж;

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-

ийн 46-д “Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хангах, зохицуулалтыг боловсронгуй болгох, зохицуулагдаагүй орхигдуулсан зарим харилцааг тодорхой болгох зорилгоор хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах. Тухайлбал, галт зэвсгийг үйлдвэрлэх, сум дахин цэнэглэхэд зөвшөөрөл олгох, түүнд тавигдах стандартыг тодорхой болгох.” гэж;

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1.1-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуульд нийцээгүй, хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, авлига, ашиг сонирхлын зөрчил гарах нөхцөл бүрдүүлсэн, зөвшөөрлийн шинжтэй зохицуулалт агуулсан болон холбогдох хууль тогтоомж шинэчлэн батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл хүчингүй болсонтой холбогдуулан дагаж мөрдөхгүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгож, хууль тогтоомжид нийцүүлэх” гэж тус тус заасан.

Галт зэвсгийн тухай хуулиар иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсгийн төрөл тогтоох, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт батлах, түүнийг ашиглах журам тогтоох, хууль сахиулах байгууллагын зориулалттай галт зэвсэг, сумны төрөл тогтоох, спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах, буудлага үйлдэх байгууламжид тавих шаардлага тогтоох, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох, галт зэвсэг худалдаалах төв ажиллуулах, салбар нээх, тухайн төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, тусгай зөвшөөрөлтэй этгээд галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх, галт зэвсгийн тооллого явуулах, хяналт тавих, хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх зэрэг харилцааг зохицуулах суурь зохицуулалтуудыг журмаар тогтоох эрхийг холбогдох этгээдэд олгосон байна.

Галт зэвсгийн тухай хуульд дүрэм, журам батлах эрх олгосон агуулгатай нийт 15 зохицуулалт байгаа бөгөөд эдгээрийг нэг бус, хэд хэдэн захиргааны байгууллага батлахаар заасан нь хууль тогтоомжийн нэгдсэн бодлого алдагдах, хуулийг батлах үед тогтоосон үзэл баримтлал өөрчлөгдөх, журам батлахдаа хуулиар тогтоогоогүй нэмэлт шалгуур, шаардлага тогтоох, нийтийн ашиг сонирхлоос илүү тодорхой бүлгийн ашиг сонирхолд нийцүүлэн зохицуулалтыг өөрчлөх, улмаар хүний эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Иймд хууль тогтоомж тодорхой, иж бүрэн, тогтвортой, нэг мөр хэрэгжих зарчмыг хангах үүднээс журмаар зохицуулж байгаа суурь шинжтэй харилцааг хуулийн түвшинд нарийвчлан тусгах, хуулийг хэрэгжүүлэх явцад үүсэж буй практик хүндрэл, хэрэгцээ шаардлагыг харгалзан Галт зэвсгийн тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 1400 орчим галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд шинээр худалдан авч өмчилж, эзэмшиж байгаа бөгөөд үүний 90 гаруй хувийг ан агнуурын зориулалтаар, үлдсэн хувийг харуул хамгаалалт, спорт сургалт, үзмэр цуглуулгын зориулалтаар ашиглаж байна.

Галт зэвсгийн тухай хуулийг хэрэгжүүлж буй практикт тулгуурлан тус хуулийг боловсронгуй болгох дараах шаардлага үүсээд байна.

Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсгийг ерөнхий шинжээр тодорхойлсон боловч галт зэвсгийн төрлийг нарийвчлан ангилаагүйгээс иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа галт зэвсгийг бүртгэлжүүлэхэд хүндрэл үүсэж байна. Мөн Галт зэвсгийн тухай хууль болон Амьтны тухай хуульд ан агнуурын зориулалттай галт зэвсгийг өөр өөр нэр томъёогоор тодорхойлсон нь ойлголтын зөрүү үүсгэж, хууль хоорондын уялдааг алдагдуулж байна.

2026 оны эхний байдлаар Монгол Улсад нийт 52,183 ширхэг галт зэвсэг бүртгэлтэй байгаагаас зориулалтаар нь ангилбал ан агнуурын 48,655, спорт сургалтын 2,399, харуул хамгаалалтын 675, үзмэр цуглуулгын 454 ширхэг галт зэвсэг байна.¹

Бүртгэлтэй галт зэвсгийг онцгой төрлөөр нь авч үзвэл богино галт зэвсэг (гар буу) 1,583, ажиллагааны хувьд хагас автомат урт буу 2,516, холын зайд өндөр нарийвчлалтай буудах зориулалттай галт зэвсэг 10,724 ширхэг байна.

2023-2025 онд нийт 4,255 ширхэг галт зэвсгийг шинээр бүртгэн гэрчилгээжүүлж, 19,147,500 төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бөгөөд галт зэвсэгтэй холбоотой 21 зөрчлийг илрүүлж, 840,000 төгрөгийн торгууль ногдуулсан байна. Мөн 2025 онд гэмт хэрэг, зөрчлийн улмаас 224 ширхэг галт зэвсэг, 11 ширхэг галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, 661 ширхэг сумыг хураасан байна.

Үүнээс гадна эх сурвалж нь тодорхойгүй, бүртгэлгүй байсан нийт 203 ширхэг галт зэвсгийг шинээр бүртгэснээс нийслэлд 15, орон нутагт 188 ширхэг галт зэвсэг бүртгэгдсэн байна.

Сүүлийн гурван жилийн статистик мэдээллээс үзэхэд жилд дунджаар 1,418 ширхэг галт зэвсэг шинээр бүртгэгдэж, 307 эзэмшигч шилжин бүртгэгдэж байгаа нь галт зэвсгийн тоо, хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Энэ нь галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг илүү нарийвчлан зохицуулах, хууль хоорондын зөрчлийг арилгах шаардлагатайг илтгэж байна.

Мөн галт зэвсгийг шилжүүлэн авсан этгээд галт зэвсгээ бүртгүүлэх, гэрчилгээжүүлэх, галт зэвсгийг хаяж үрэгдүүлсэн, эсхүл өмчлөгч, эзэмшигч нас барсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх үүргээ биелүүлэхгүй байх тохиолдол гарч байгаа нь галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны эргэлт, тэдгээрийн тоо бүртгэлд хяналт тавихад хүндрэл учруулж байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллээс харахад жилд дунджаар 7 хүн гэмтэж, 4 хүн нас барж байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь галт зэвсгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангагдаагүй, галт зэвсэг эзэмшигчдийн мэдлэг, хариуцлага хангалтгүй байгаагаар холбоотой байна. Иймд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой иргэний хариуцлагыг нэмэгдүүлэх, галт зэвсгийн бүртгэл, хяналтын мэдээллийн санг боловсронгуй болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага үүсээд байна.

Түүнчлэн 2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт галт зэвсэгтэй холбоотой иргэний болон харуул хамгаалалтын

¹ Цагдаагийн ерөнхий газраас гаргасан тоо

зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор заасан. Гэвч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Галт зэвсгийн тухай хуульд сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд сум дахин цэнэглэх үйлдвэр байгуулах, тус төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах нөхцөл, шаардлага, аюулгүй ажиллагааны стандарт зэрэг зохицуулалт огт тусгагдаагүй байна. Иймд сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, 20.4 дүгээр зүйлд заасан Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших, 20.5 дугаар зүйлд заасан Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх, 20.6 дугаар зүйлд заасан Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах, 28.7 дугаар зүйлд Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших, 28.8 дугаар зүйлд заасан Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, 28.9 дүгээр зүйлд заасан Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих зэрэг гэмт хэргүүдэд "галт хэрэгсэл" гэх нэр томъёог хэрэглэсэн байдаг боловч Галт зэвсгийн тухай хуульд "галт хэрэгсэл" гэдэгт юуг хамааруулах талаар зохицуулалт байхгүй байна. Одоогоор Улсын дээд шүүхийн 2010 оны "Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 14 дүгээр тогтоолын 11 дэх хэсэгт "Хуулийн 185, 186, 187, 188 дугаар зүйлүүдэд заасан "галт зэвсэг /ангийн буунаас бусад/..." гэдгийг Галт зэвсгийн тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно. Дээрхи зүйлүүдэд заасан "...байлдааны галт хэрэгсэл..." гэж ангийн буунаас бусад буунд хэрэглэдэг бүх төрлийн сумнууд, тийрэлт, шидэлтийн хүчээр байнд хүрч дэлбэрэлтийн хүчээр байг устгах зориулалт бүхий зэвсгийн зүйлсийг хэлнэ." гэж заасанг хэрэглэж байгаа болно. Гэтэл байлдааныхаас бусад галт хэрэгсэлийг тодорхойлоход дээр тайлбарыг хэрэглэх эсэх нь эргэлзээтэй бөгөөд сум хууль бусаар хил нэвтрүүлсэн, бэлтгэсэн зэрэг үйлдэлд эрүүгийн хариуцлага тооцоход эрх зүйн зохицуулалтын зөрүүтэй, хийдэлтэй байдлаас зарим тохиолдолд ял шийтгэгдэхгүй байх боломжтой байгаа тул галт зэвсэг болон түүнийг тойрсон бусад ойлголт болон хэрэгслийн нэр томъёог хуульд тодорхой, ойлгомжтой байдлаар, олон улсын чиг хандлагад нийцүүлэн тодорхойлж өгөх шаардлагатай байна.

Галт зэвсгийн тухай хуулиар Монгол Улсад галт зэвсэг, сум худалдах төв ажиллуулах, тэдгээрийг улсын хилээр импортлох зөвшөөрөл олгох, хилээр нэвтрүүлэх журам тогтоох, галт зэвсгийг хураах, хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх зэрэг харилцааг захиргааны байгууллагад эрх шилжүүлэх буюу захиргааны хэм хэмжээний актаар зохицуулахаар тусгасан байна. Гэвч дээрх зохицуулалт нь галт зэвсгийн эргэлт, аюулгүй байдал, хүний үндсэн эрх, эрх чөлөөтэй шууд холбоотой суурь харилцааг журам, зааврын түвшинд зохицуулах нөхцөлийг бүрдүүлж, энэ чиглэлээр төрийн нэгдсэн бодлого алдагдах, хуулиар тогтоох ёстой материаллаг болон процедурын үндсэн зохицуулалт захиргааны актаар хязгаарлагдах эрсдэлийг бий болгож байна. Иймд дээрх эрх олгосон зохицуулалтад дахин дүн шинжилгээ хийж, галт зэвсэгтэй

холбоотой суурь шинжтэй харилцааг хуулийн түвшинд тодорхой тусгах шаардлага үүсээд байна.

Түүнчлэн Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлд галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрлийг хууль зүй, спорт, байгаль орчин, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Комисс сонгон шалгаруулалтын журмаар шийдвэрлэхээр зохицуулсан боловч тус Комиссын эрх хэмжээ, үүрэг, шийдвэр гаргах ажиллагаа, хариуцлагын тогтолцоог тодорхой тусгаагүй байна. Иймд галт зэвсэг, сум болон холбогдох дагалдах хэрэгслийн эргэлтэд тавих хяналт, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ил тод, нэгдмэл, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Комиссын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн зохицуулалтыг хуулийн түвшинд нарийвчлан тусгах шаардлагатай байна.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр нэр томьёоны тодорхойлолтыг нарийвчлан боловсронгуй болгоно. Тухайлбал, иргэний зориулалттай галт зэвсэгт ан агнуур, спорт-сургалт, харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсгийг хамруулан тодорхойлсон боловч эдгээр галт зэвсгийг ашиглах, эзэмших, өмчлөх харилцааг ялгаатай байдлаар зохицуулж ирсэн нь хуулийг хэрэглэх явцад ойлголтын зөрүү, маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор шүүхийн журмаар шийдвэрлэгдсэн маргаан гарсан бөгөөд цаашид ижил төрлийн маргаан тогтмол гарах эрсдэлтэй байна.

Түүнчлэн өмнө нь журам, зааврын түвшинд зохицуулж байсан галт зэвсэг, сум, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, үйлдвэрлэх, нийтэд худалдах, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах журам, галт зэвсэг, сум хадгалах байр, агуулахын аюулгүй ажиллагааны шаардлага, галт зэвсгийн тооллого, хураах, устгах, галт зэвсэг, сум ашиглан үйл ажиллагаа явуулах байгууламж /тир/-тэй холбоотой харилцааг хуулийн түвшинд зохицуулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Хуулийн төслийг нийт 11 бүлэгтэйгээр боловсруулж, галт зэвсэгтэй холбоотой харилцааг дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг:Хуулийн нэр томьёоны тодорхойлолт;

Хоёрдугаар бүлэг:Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны төрөл;

Гуравдугаар бүлэг:Галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, бүртгүүлэх, хадгалах болон холбогдох хязгаарлалтын зохицуулалт;

Дөрөвдүгээр бүлэг:Галт зэвсэг, сум худалдах, худалдан авах, өвлүүлэх, бэлэглэх, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумыг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий комиссын үйл ажиллагаа;

Тавдугаар бүлэг:Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох болон сонгон шалгаруулалтын журам;

Зургаадугаар бүлэг:Галт зэвсэг, сум худалдах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зохицуулалт;

Долоодугаар бүлэг:Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдох харилцаа;

Наймдугаар бүлэг:Галт зэвсэг, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйлдвэр, хадгалах байр, агуулахын аюулгүй ажиллагааны шаардлага;

Есдүгээр бүлэг:Буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага;

Аравдугаар бүлэг:Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх зохицуулалт;

Арваннэгдүгээр бүлэг:Галт зэвсгийг авч явах, тээвэрлэхэд тавих шаардлага, галт зэвсгийн тооллого, галт зэвсэг, сум хураах болон шилжилтийн үеийн зохицуулалт.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй бөгөөд нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй гэж үзэж байна. Харин хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл өмчлөх, эзэмших, ашиглах, үйлдвэрлэх эрхийг тодорхой, ойлгомжтой зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Мөн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн эргэлтэд тавих хяналтын тогтолцоо боловсронгуй болж, болзошгүй хор уршгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах нөхцөл сайжирна. Түүнчлэн галт зэвсгийн хууль бус хэрэглээг илүү тодорхой зохицуулах боломж бүрдэх бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдаж байгаа галт зэвсгийн дийлэнх нь харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг байгааг харгалзан үзвэл уг хуулийн төсөл батлагдсанаар нийгэмд үүсч буй сөрөг үр дагаврыг бууруулах ач холбогдолтой болно.

Дөрөв.Хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төслийг дагалдуулан Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

-----oOo-----